



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/1625

Мандалговь

Шүлхийн дархлаажуулалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.6 дах заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/108 дугаар тушаалын дагуу 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Өндөршил, Цагаандэлгэр сумдын малчид, мал бүхий иргэдийн үхэр болон бог малыг гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулах тул зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг нэр бүхий сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

Гурав. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, шуурхай үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очирт)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

492010360

04 Аймгийн Засаг даргын 2020 оны
.....дугаар сарын 30-ны өдрийн 165 дугаар
захирамжийн хавсралт

ШҮЛХИЙН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ВАКЦИНД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	Малчин өрх	Шүлхийн дархлаажуулалтанд хамрагдах малын тоо				Тун
			Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	
1	Баянжаргалан	234	3943	83683	62739	150365	77200
2	Говь-Угтаал	279	3225	103539	92786	199550	101400
3	Гурвансайхан	495	5093	169210	127310	301613	153400
4	Өлзийт	585	2942	160188	177842	340972	172000
5	Өндөршил	269	3668	94174	77654	175496	89600
6	Цагаандэлгэр	273	3297	75090	64759	143146	73200
ДҮН		2135	22168	685884	603090	1311142	666800